

- Чадварын төрлийн түүрэгийн*
- 4.2.5** Илт худал мэдээлэл бүхий тендер ирүүлснийг эрх бүхий хуульд заасан эрх бүхий байгууллагатогтоосон;
- 4.2.6** Сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлигын, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон болохыг шүүх тогтоосон;
- 4.2.7** Тендерт оролцогч нь (туслан гүйцэтгэгч бүрийг оролцуулан) уг төслийн зураг төсөл, техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээг хянах зөвлөхөд нэр нь дэвшигдсэн этгээдтэй нэгдмэл сонирхолтой бол;
- 4.2.8** Тендер шалгаруулалтад оролцож байгаа хоёр буюу түүнээс дээш тооны тендерт оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;
- 4.2.9** Тендерийн баримт бичгийн ТОӨЗ-ны 16дугаар зүйлд хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрснөөс бусад тохиолдолд тендерт оролцогч нэгээс дээш тендерт ирүүлсэн бол; (Гэвч энэхүү заалт нь аливаа этгээдийг нэгээс дээш тендерт туслан гүйцэтгэгчээр оролцохыг, эсхүл нэг тендер шалгаруулалтад нэгээс олон багцад тендерт ирүүлэхийг хязгаарлахгүй)
- 4.3.** Тендерт оролцогч 4.2.1 - 4.2.9-д дурдсан нөхцөл үүссэн эсэх мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж өгөх үүрэгтэй. Эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу тендерт оролцогч холбогдох баримт, нотолгоог захиалагчид ирүүлнэ.
- 4.4.** Тендерт оролцогч нь эрх бүхий эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно. Үүнд:
- (a) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний эхээс хийсэн хуулбар, эсвэл үүсгэн байгуулагдсан улсын түүнтэй адилтгах бусад баримт бичиг;
 - (b) тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурахэтгээдийн итгэмжлэл;
 - (v) ТШӨХ-д шаардсан бол тухайн төрлийн ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрөл;
 - (g) Шүүх, эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэр. Тендерт оролцогчийн хувьд ТОӨЗ-ны 4.2.2, 4.2.4, 4.2.5 болон 4.2.6 –д дурдсан нөхцөл байдал үүсч байсан бол энэ тухайг захиалагчид мэдэгдэж холбогдох шүүх, эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийг тендерийн хамт ирүүлэх үүрэгтэй.
- 5. Тендерт оролцогчийн гэрээг хэрэгжүүлэх чадвар**
- 5.1.** Бүх тендерт оролцогч нь 3 дугаарбүлэгт заасан “Тендерийн маягт, чадварын мэдээлэл, зөвшөөрлийн бичиг” –ын дагуу мэдээлэл ирүүлэх, ажил гүйцэтгэхээр санал болгож буй аргачлал болон хуваарь, шаардлагатай бол зураг, ажлын графикийн хамт ирүүлэх ёстой.
- 5.2.** Хэрэв захиалагч урьдчилсан сонголт явуулаагүй бөгөөд ТШӨХ-д өөрөөр заагаагүй бол бүх тендерт оролцогч гэрээг хэрэгжүүлэх чадварыг тогтоохтой холбогдуулан захиалагчийн шаардсан дараах мэдээллийг нотлох баримт болгон тендерийн хамт ирүүлнэ. Үүнд:

- норматив*
- (а) хуулийн этгээдийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээ болон тусгай зөвшөөрлийн дагуу хийгдэх ажлын тухайд уг ажлыг гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн эхээс хийсэн хуулбар, тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл;)
 - (б) санхүүгийн чадавхийг харуулах ТШӨХ-д заасан жилийн санхүүгийн тайлан. Хэрэв ТШӨХ-д тусгайлан заасан бол санхүүгийн тайланга аудитаар баталгаажуулсан байна;
 - (в) гэрээг хэрэгжүүлэх, удирдах болон техникийн голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл;
 - (г) ТШӨХ-д заасан хугацаанд хийж гүйцэтгэсэн барилгын ажлын нийт мөнгөн дүнг жил жилээр харуулсан жагсаалт;
 - (д) тухайн тендерт оролцогч ТШӨХ-д заасан хугацаанд төрөл болон хэмжээгээр ижил төстэй ажил хийж гүйцэтгэсэн туршлагыг жил жилээр харуулсан мэдээлэл, одоо хийж байгаа болон хийхээр төлөвлөсөн ажлын тухай дэлгэрэнгүй мэдээлэл, тэдгээр гэрээний талаар лавлах мэдээлэл авч болох үйлчлүүлэгч, захиалагчийн хаяг;
 - (е) гэрээг гүйцэтгэхэд ашиглагдах санал болгож буй үндсэн машин механизм, тоног төхөөрөмжийн нэр төрөл(зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж, машин механизмын жагсаах);
 - (ё) гэрээг гүйцэтгэхэд эргэлтийн хөрөнгө хүрэлцээтэй эсэхийг нотлохбаримт бичиг (үүнд зээл авах баталгаажсан эрх болон боломжтой санхүүгийн бусад эх үүсвэр);
 - (ж) захиалагч харилцагч банкнаас нь тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдэгдэл;
 - (з) одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцогчийн оролцсон аливаа шүүхийн зарга, маргааны талаарх мэдээлэл;
 - (и) ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд гэрээний үнийн дүнгийн 10-аас дээш хувьтай тэнцэх ажлыг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх бол түүнийг түншлэл гэж үзэж, түншлэгч компаний талаарх мэдээллийг мөн ирүүлнэ. Туслан гүйцэтгүүлэх ажлын талаарх мэдээллийг тендерийн саналд тусгаж ирүүлнэ. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох ажлын нийт өртөгийн дээд хязгаарыг ТШӨХ-д тодорхойлно.
- норматив
тодорхойлж*

5.3. Тендерт оролцогч ТОӨЗ-ны 1.1-д заасан ажлыгтүйцэтгэх гэрээг хэрэгжүүлэхийн тулд дор дурдсан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангасан байна: Үнд:

- (а) ТШӨХ-д заасан хугацааныаль нэг жилд гүйцэтгэсэн ажлын борлуулалтын хэмжээ нь ТШӨХ-д заасан мөнгөн дүнгэс багагүй байх;
- (б) ТШӨХ-д заасан жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй, доод тал нь нэг удаагийн ажил гүйцэтгэх гэрээний үндсэн гүйцэтгэгчээр ажилласан туршлага(энэ шаардлагыг хангахын тулд нэрлэсэн ажлын доод тал нь 70 хувийг нь гүйцэтгэсэн байх шаардлагатай);

- (в) ТШӨХ-д заасан үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг цаг хугацаанд нь олж (өөрийн, түрээслэх/гэрээ шаардах/, авах г.м.) бэлэн байлгах санал;
- (г) гэрээнд заасан ажилтай төрөл, дүнгээрээ дүйцэх ажил дээр ТШӨХ-д зааснаас доошгүй хугацаандын гэрээг хариуцаж ажилласан туршлага бүхий ерөнхий инженертэй байх;
- (д) бусад гэрээт ажилд ашиглагдах буюу ашиглаж буй хөрөнгө болон энэ гэрээний дагуу хийгдэж болох урьдчилгаа телбөрийг оролцуулахгүйгээр түргэн хөрөнгө чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээл нь ТШӨХ-д дурдсан дүнгээс багагүй байх.
- (е) сүүлийн ТШӨХ-д дурдсан жилийн хугацаанд ашигтай ажилласан байх.

5.4. Тендерт оролцогч түншлэлийн хувьд 5.3 (а) ба (д)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлохын тулд түншлэлийн гишүүн тус бүрийн үзүүлэлтийг хооронд нь нэмнэ. Гэхдээ гишүүн тус бүр 5.3 (а), (б) болон (д)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийн доод тал нь 25 хувийг, төлөөлөх эрх бүхий гишүүн доод тал нь 40 хувийг хангасан байх ёстой.

Энэ шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд түншлэлийг тухайн чадварын шаардлагыг хангаагүй гэж үзэж тендерээс нь татгалзана.

Түншлэл 5.3(б), (в), (г)-д заасан чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, санхүүгийн нөөц бололцоог харгалзаж үзэхгүй. Харин туслан гүйцэтгэгчээргүйцэтгүүлэх ажилд тусгай зөвшөөрөл шаардлагдах бол туслан гүйцэтгэгч уг шаардлагыг хангасан байвал зохино.

Түншлэлийн гишүүн тус бүр 5.3(е)-г хангасан байх ёстой.

5.5. Тендерт оролцогч чадварын доод шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг тодорхойлоход түүний туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, санхүүгийн нөөц бололцоог харгалзаж үзэхгүй. Харин туслан гүйцэтгэгчээргүйцэтгүүлэх ажилд тусгай зөвшөөрөл шаардлагдах бол туслан гүйцэтгэгч уг шаардлагыг хангасан байвал зохино.

5.6. Тендерт оролцогч тендерийн үнэлгээнд 7.5 хувийн давуу эрх эдлэх хүсэлтэй бол тендерт оролцогч нь хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасныг хангаж байгаагэдгийг нотлон ирүүлэх шаардлагатай.

6. Тендерт оролцогч түншлэл

6.1. Хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг тендерт оролцогч /цаашид талуудыг хамтад нь “түншлэл” гэх, тус бүрийг нь “түншлэлийн гишүүн” гэх/ болж тендер шалгаруулалтад оролцох тохиолдолд ТШӨХ-д өөрөөр заагаагүй бол дараах шаардлагыг хангасан байна:

- (а) түншлэлийн гишүүн бүр энэхүү ТОӨЗ-ны 5.2-т заасан бүх мэдээллийг тус бүрдээ гаргаж, тендерийн хамт ирүүлнэ.
- (б) түншлэлийн гэрээ нь Иргэний хуульд заасан хамтран ажиллах гэрээний шаардлага хангасан байна;
- (в) ТОӨЗ-ны 1.1-д заасан хэрэгжүүлэхэд бүх гишүүн хамтран болон тус тусдаа хүлээх хариуцлагыг хамтран ажиллах гэрээнд тодорхойлсон байх;
- (г) түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авах, төлбөр тооцоо хийхэд тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох;

	(д) нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөрийг зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй тооцохыг хамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх;
	(е) түншлэлийн гэрээний хувийг тендерийн хамт ирүүлэх.
6.2. Дээрх шаардлагыг түншлэлийн гэрээнд тусгааагүй тохиолдолд түншлэлийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана.	
7. Тендер шалгаруулалтад оролцох зардал	7.1. Тендерт оролцогч тендерийг бэлтгэх, захиалагчид ирүүлэхтэй холбогдон гарах бүх зардлыг өөрөө бүрэн хариуцах бөгөөд захиалагч ямар ч нөхцөлд энэхүү зардалтай холбогдох хариуцлага хүлээхгүй.
8. Ажлын талбайтай танилцах	8.1. Ажлын талбай, түүний байршил, орчны нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж судлан тендер бэлтгэх, гэрээ байгуулахад шаардлагатай байж болох бүх мэдээллийг тендерт оролцогч авч ашиглаж болно. Ажлын талбайтай газар дээр нь очиж танилцах зардлыг тендерт оролцогч өөрөө хариуцна.

Б. ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

9. Тендерийнбари мт бичгийн агуулга	9.1. Тендерийн баримт бичиг нь дор дурдсан бүлгүүдийг агуулсан З хэсэг баримт бичиг болон ТОӨЗ-ны 12 дугаар зүйлийн дагуу оруулсаннэмэлт өөрчлөлтөөс бүрдэнэ:
---	---

I ХЭСЭГ

- Бүлэг 1. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа
 Бүлэг 2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт
 Бүлэг 3. Тендер шалгаруулалтад ашиглах жишиг маягт
 - Тендерийн маягт
 - Чадварын мэдээллийн маягт
 - Гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл
 - Гэрээний маягт

II ХЭСЭГ

- Бүлэг 4. Ажлын шаардлага, техникийн тодорхойлолт

III ХЭСЭГ

- Бүлэг 5. Гэрээний ерөнхий нөхцөл
 Бүлэг 6. Гэрээний тусгай нөхцөл
 Бүлэг 7. Гэрээний маягт
 - Гэрээний маягт
 - Гүйцэтгэлийн баталгааны маягт
 - Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт

Хавсралт: Тендерийн урилга

- 9.2. Захиалагчийн нийтэлсэн тендерийн урилга нь тендерийн баримт бичгийн хэсэг болохгүй.
- 9.3. Тендерт оролцогч тендерийн баримт бичиг дэх зааварчилгаа, нөхцөл, шаардлагатай маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх нь зүйтэй. Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх нь түүний тендерээс татгалзах үндэслэл болж болно.

10. Тендерийн баримтбичгийг тодруулах	<p>10.1. Тендерт оролцохыг сонирхогч аливаа этгээд нь тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах шаардлагатай бол энэ тухай хүсэлтээ бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоо (“утсан холбоо”-нд зөвхөн факсыг хамруулна)-гоор ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар ирүүлнэ.</p> <p>Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ТШӨХ-д заасан хоногийн өмнө хүлээн авсан хүсэлтэд хариу өгнө. Хүсэлтийн агуулга, түүнд өгөх захиалагчийн хариуг хүсэлтийн эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчдод бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.</p>
11. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт	<p>10.2. Тухайн тодруулгын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл энэхүү ТОӨЗ-ны 12 дугаар зүйл, 20.2 дахь хэсэгт заасныг баримтална.</p>
	<p>11.1. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтыг зохион байгуулах талаар ТШӨХ-д заасан бол тендерт оролцохыг сонирхогч этгээдтүүний томилсон төлөөлөгч нарыг урьж оролцуулна. Уг уулзалт нь тендер бэлтгэх явцад үүсч болох аливаа асуудлыг тодруулах, энэ талаар тендерт оролцогчдоос тавьж буй асуултанд хариу өгөх зорилготой байна.</p>
	<p>11.2. Тендерт оролцохыг сонирхогч өөрийн асуултыг дээрх уулзалтыг зохион байгуулахаас өмнө бичгээр ирүүлж болно.</p>
	<p>11.3. Эдгээр асуултын агуулга, түүний талаарх хариуг тусгасан уулзалтын тэмдэглэл болон уулзалтын дараагаар бэлтгэгдсэн бусад хариу зэргийг асуулт тавьсан эх сурвалжийг дурдалгүйгээр тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ.</p>
	<p>11.4. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтын үр дүнд захиалагч тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзвэл энэхүү ТОӨЗ-ны 12, 24.2-т заасныг баримтална.</p>
	<p>11.5. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалтад оролцоогүй шалтгаанаар тендерт оролцохыг сонирхогч этгээдийн тендерт оролцох эрхийг хязгаарлаж болохгүй.</p>
12. Тендерийн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах	<p>12.1. Захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.</p>
	<p>12.2. Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлт нь тендерийн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд түүнийг тендерийн баримт бичиг худалдан авсан бүх тендерт оролцогчид бичгээр гаргаж шуудан, эсхүл утсан холбоогоор нэгэн зэрэг мэдэгдэнэ. Тендерт оролцогч нэмэлт өөрчлөлт тус бүрийг хүлээн авсан тухайгаа захиалагчид утсан холбоогоор мэдэгдэх үүрэгтэй.</p>
	<p>12.3. Шаардлагатай бол тендерийн баримт бичигт орсон нэмэлт, өөрчлөлтийг тендер бэлтгэхдээ авч үзэхэд шаардагдах хангалттай хугацаа тендерт оролцогчдод олгох үүдиээс захиалагч ТОӨЗ-ны 24.2-т заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгаж болно.</p>
B. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
13. Тендерийн хэл	<p>13.1. Тендер, түүнчлэн тендертэй холбоотой асуудлаар захиалагч тендерт оролцогчийн хооронд харилцаж буй албан бичиг, захидалууд болон бусад баримт материалыг тендерт оролцогчид өгсөн заavarчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх баримт бичиг нь монгол хэл дээр, гадаадын этгээд худалдан авах ажиллагаанд оролцох эрхтэй бол тэдгээр</p>

нь ТШӨХ-д заасан хэл дээр байна. Тендерийн барим бичгийн монгол хэл дээрх хувь гадаад хэл дээрхтэй зөрчилдвэл монгол хэл дээр бэлтгэсэн ТББ-ийн заалтыг баримтална

13.2. Аливаа тендерийг дагалдах баримт бичиг, хэвлэмэл материал нь өөр хэл дээр байж болох бөгөөд энэ тохиолдолд тэдгээрийн тендерт холбогдох хэсгийг ТШӨХ-д заасан хэл рүү хөрвүүлсэн орчуулгыг тендерт оролцогч давхар бэлтгэж ирүүлэх бөгөөд уг орчуулгыг үндэслэн тендерийн үнэлгээнд харгалзах болно.

13.3. Тендерт оролцогч тендерээ Монгол хэл болон ТШӨХ-д заасан гадаад хэлний аль нэг дээр бэлтгэж ирүүлэх бөгөөд нэгээс дээш хэл дээр тендерээ бэлтгэж ирүүлэхийг хориглоно. Шалгарсан тендерт оролцогчтой байгуулах гэрээг түүний тендер ирүүлсэн хэл дээр байгуулна.

14. Тендерийн иж бүрдэл

14.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

- (а) ТОӨЗ-ны 15дугаар зүйлд заасны дагуу бэлтгэсэн тендерийн маягт болонүе шатны ажлын хуваарь;
- (б) ТОӨЗ-ны 15, 17 дугаар зүйлийн дагуу бэлтгэж ирүүлэх үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
- (в) Захиалагч ТОӨЗ-ны 21 дүгээр зүйлд ирүүлэхийг шаардсан тендерийн баталгаа;
- (г) тендерт оролцогчийг төлөөлж ТОӨЗ-ны 22 дугаар зүйлд заасны дагуу тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийгбаталгаажуулж бичгээр гаргасан байх, түүний итгэмжлэл;
- (д) тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай ТОӨЗ-ны 4 дүгээр зүйлд заасан нотлох баримтууд;
- (е) тендерт оролцогч нь тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай ТОӨЗ-ны 5 дугаар зүйлд заасан нотлох баримтууд;
- (ё) ТОӨЗ-ны 19дүгээр зүйлд заасны дагуу бэлтгэж ирүүлэх техникийн санал;
- (ë) ТОӨЗ-ны 16дугаар зүйлд захиалагч тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд ирүүлэх хувилбарт тендер;
- (ж) ТОӨЗ-ны дагуу бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад буюу ТШӨХ-д шаардсан материал.

*яргын
учиний
баталгаа*

—

15. Тендерийн маягт болон үе шатны ажлын хуваарь

15.1. Тендерт оролцогч нь 3 дугаарбүлэг буюу тендерийн жишиг маягуудаасзохих маягтыг ашиглан тендерийн санал ба үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарийг бэлтгэж ирүүлнэ. Эдгээр маягтын үг, өгүүлбэрт утга агуулгыг нь өөрчилсөн буюу орхигдуулсан аливаа өөрчлөлт хийхийг зөвшөөрөхгүй. Маягт дахь бүх хоосон зайд шаардсан мэдээллийг нөхөж бичнэ.

**16. Хувилбарттенд
ер**

16.1. ТШӨХ-д тусгайлан зааснаас бусад тохиолдолд тендерт оролцогч тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн зөвхөн нэг тендер ирүүлэх ба хувилбарт тендер ирүүлэхийг үл зөвшөөрнө.